

## МОНГОЛБАНК-нд

## Ариг банкны ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Түвшинтамирын ажлын тайлан

2024 оны 01 дүгээр улирал

2024 оны 04 дүгээр  
сарын 01-ний өдөрУлаанбаатар  
хот

“Ариг банк” ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл /ТУЗ/-ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дарга, Эрсдэлийн удирдлагын болон Засаглал, нэр дэвшүүлэх хорооны гишүүн Д.Түвшинтамир нь 2024 оны 1 дүгээр улиралд дор дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллалаа. Үүнд:

2024 оны 1 дүгээр улиралд ТУЗ-ийн ээлжит, ээлжит бус хурлууд, Аудитын хороо, Эрсдэлийн удирдлагын болон бусад хорооны нийт 13 удаагийн хуралд оролцсон бөгөөд өөрийн даргаар ажиллаж буй хорооны хурлуудыг удирдаж, холбогдох тогтоолын төсөл, шийдвэр, дүгнэлт, асуудалд саналаа өгч ажилласан болно. Хүснэгтээр харуулбал:

Хуралд оролцсон байдлаар №1:

№	Засаглал, нэр дэвшүүлэх хорооны хурал	ТУЗ-ийн хурал	Аудитын хорооны хурал	Эрсдэлийн хорооны хурал	Нийт оролцсон хурал
1.	1	7	4	1	13

Хурал хуралдсан огноогоор №2:

№	Засаглал, нэр дэвшүүлэх хорооны хурал	ТУЗ-ийн хурал	Аудитын хорооны хурал	Эрсдэлийн хорооны хурал
1.	2024-02-27	2024-01-23 2024-01-26 2024-02-16 2024-02-19 2024-03-01 2024-03-11 2024-03-25	2024-01-11 2024-01-19 2024-03-07 2024-03-12	2024-01-19

Хараат бус гишүүнээр хуралд заавал санал өгсөн байдлаар №3:

№	Сонирхлын зөрчилтэй асуудал	Татгалзсан санал өгсөн асуудал
1.	3	1

Тайлант хугацаанд цахимаар 1 удаа, эчнээ санал хураалтаар 1 удаа санал өгсөн бөгөөд 1 удаа чөлөө авснаар нийт 14 удаагийн хуралд 92,9%-ийн ирцтэй ажилласан байна. Үүнээс 4 удаа Аудитын хорооны хурлын даргаар, тус бүр 1 удаа Засаглал, нэр дэвшүүлэх хороо болон Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүнээр тус тус ажиллаж, санал зөвлөмжөө өгч, шийдвэр гаргалтад оролцож, дор дурдсан асуудлуудыг хэлэлцсэн.

ТУЗ-ийн гол шийдвэрлэсэн асуудлуудаас танилцуулвал:

1. Банкны ТУЗ нь “Банкны 2024 бүтэц, орон тоо, төсөв төлөвлөгөө”-г батлахдаа ТУЗ-ийн 3 удаагийн хурлаар өргөтгөсөн байдлаар холбогдох банкны удирдлагуудыг оролцуулан хэлэлцүүлж, нягт нямбай хянаж ажилласнаар 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдөр эцэслэн батлав.
2. “Ариг банк” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 10:00 цагт Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Их Хуралдай Бизнес төв, 14-р давхрын Ариг банкны төв байрны хурлын танхимд хуралдуулахаар шийдвэрлэв.
3. 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн ТУЗ-ийн ээлжит бус хурлаар “Банкыг тогтворжуулах төлөвлөгөө”-г баталж, Банкны 2023 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлантай танилцаж дүгнэлт гаргав. Мөн хурлаар ТУЗ-ийн 2023 оны үйл ажиллагааны тайлантай танилцаж, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж үнэлэлт, дүгнэлт авахаар шийдвэрлэв.
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн ур чадварын матриц, түүнийг тодорхойлох журамд зарчмын тодорхой санал өгч батлав.

ТУЗ-ийн хараат бус гишүүний хувьд:

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалтын дагуу сонирхлын зөрчил үүсэж болзошгүй 6 удаагийн хэлцэлд саналаа өгсөн. Санал өгөөгүй хэлцэл байхгүй. 6 удаагийн зөрчил үүсэж болзошгүй хэлцлийг ангилж харуулбал:

1. “Номин Холдинг” ХХК-тай банкны “Хүү, шимтгэлийн ерөнхий нөхцөл”-ийн дагуу “Кредит картын үйлчилгээ” бүтээгдэхүүнээр хамтран ажиллахыг дэмжсэн,
2. “Голден пропертиз” ХХК-тай банкны шинээр нэвтрүүлж буй “Франчайз зээлийн эрх” бүтээгдэхүүнээр хамтран ажиллахыг дэмжсэн,
3. “Голден пропертиз” ХХК-тай банкны дотоод эх үүсвэрээр орон сууц, амины орон сууц, хашаа байшин, бизнесийн зориулалтаар ашиглах үл хөдлөх хөрөнгийг зээлээр борлуулах тухай “Хамтран ажиллах гэрээ” байгуулан ажиллахыг тус тус дэмжсэн.

Дээрх хэлцлүүд нь бүгд харьцуулсан судалгаатай, банкны бүтээгдэхүүнүүдийг өргөжүүлсэн, харилцагч татсан хэлцлүүд гэж дүгнэсэн учраас сонирхлын зөрчилгүй гишүүд 100%-ийн саналтайгаар дэмжиж шийдвэрлэсэн.

ТУЗ-ийн хараат бус гишүүний хувьд бусад гишүүдээс санал зөрсөн буюу татгалзсан 1 асуудал нь Хувьцаа эзэмшигчдэд банкны 2023 оны ашгаас ногдол ашиг хуваарилах тухай асуудал байсан бөгөөд банкыг тогтвортой хөгжүүлэх, тэлэхэд ихээхэн хөрөнгийн худалдан авалт шаардлагатай, Монголбанкнаас тавьдаг шаардлагыг өндөр түвшинд хангах зэргийг харгалзан үзэж эсрэг санал өгсөн болно.

ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны даргын хувьд:

1. Ариг банкны ТУЗ-ийн дэргэдэх Дотоод аудитын газрын 2023 оны үйл ажиллагааны тайлантай танилцаж, ажлын гүйцэтгэл нь 86%-тай гэж үнэлсэн.

2. Дотоод аудитын газрын 2024 оны төлөвлөгөө, бүтэц орон тоо, төсөвтэй танилцаж, холбогдох санал зөвлөмж өгч ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэхээр дэмжив.
3. ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны 2023 оны үйл ажиллагааны тайлантай танилцан хэлэлцэж, цаашид хийж хэрэгжүүлэх үйл ажиллагаанд нь санал зөвлөмж өгч ажилласан.
4. СОВИТ тогтолцооны дагуу аудит хийхээр санал ирүүлсэн 2 аудитын компанийг хэлэлцсэн.
5. Дотоод аудитын газраас хийсэн банкны “Хороолол”, “Хан-уул” салбарууд, “Дижитал банкны газар”-т хийсэн аудитын тайлантай танилцаж, хариу арга хэмжээний төлөвлөгөө баталж Гүйцэтгэх удирдлагад үүрэг даалгавар өгөв.
6. Гүйцэтгэх удирдлагад Дотоод аудитын газраас 2023 онд банкинд хийсэн аудитын нийт гүйцэтгэлийг ТУЗ-д танилцуулах үүрэг өгөв.
7. Дотоод аудитын газрыг бэхжүүлэхээр 2 шинэ дотоод аудиторыг сонгон шалгаруулж ТУЗ-р батлуулахаар дэмжив.
8. Дотоод аудитын газрын аудиторуудын цалин хөлсний шатлал зэрэглэлийг шинээр тогтоох саналыг ТУЗ-д танилцуулан батлуулав.

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлага, Засаглал, нэр дэвшүүлэх хорооны гишүүний хувьд:

1. Чанаргүй зээл барагдуулах үйл ажиллагааны 2023 оны тайлантай танилцав.
2. Чанаргүй зээл бууруулах 2024 оны төлөвлөгөөг Гүйцэтгэх удирдлага баталж эргэн тайлагнах үүрэг өгөв.
3. Чанаргүй зээл барагдуулах ажиллагаа, үүсэж буй эрсдэлт хүчин зүйл, түүнийг бууруулахад хууль эрх зүйн зөвлөгөөг ТУЗ болон хорооны хурал дээр илүү түлхүү санал, зөвлөмжөө өгч ажиллав.
4. Комплаенсын хэлтсийн 2023 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэж, холбогдох зөвлөмжийг өгөв.
5. Улирал бүр МУТС-гэй тэмцэх үйл ажиллагааны тайлантай танилцаж батлав.
6. Банкны Эрсдэлийн удирдлагын газрын 2023 оны жилийн үйл ажиллагаатай танилцаж хангалттай гэсэн үнэлгээ өгөв.
7. “ТУЗ-ийн гишүүдийн ур чадварын матриц, түүнийг тодорхойлох журам”-д санал өгч ТУЗ-р хэлэлцүүлэн батлуулав.

Банкны үйл ажиллагаанд ТУЗ нь үнэлэлт дүгнэлт өгч ажиллахын сацуу дараах зарчмыг баримтлан ажиллаж байна. Үүнд:

- Банкны ТУЗ-ийн үйл ажиллагаа нь Монгол Улсын Банкны тухай хууль, Компанийн тухай хууль тогтоомж болон Монгол банкнаас баталсан дүрэм, журмын дагуу явагдаж байна.
- Монгол банкнаас ирүүлсэн мэдэгдэл, шаардлагын дагуу холбогдох арга хэмжээг цаг тухайд нь хэрэгжүүлж эргэн тайлагнадаг.
- ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагаа идэвхитэй явагдаж, хороо тус бүр өөрсдийн хариуцсан ажлыг хууль тогтоомжийн дагуу зөв, гүйцэтгэл сайтай явуулахыг эрмэлздэг.
- Банкны үйл ажиллагаанд засч залруулах асуудлууд гарсан даруй бид ТУЗ-ийн түвшинд хуралдан хэлэлцэж, үйл ажиллагааг хэрхэн сайжруулах талаар холбогдох удирдлагуудыг байлцуулан удирдамж өгч, эргэн тайлагнах хугацааг зааж өгдөг. Удирдлагын баг эдгээр шаардлагыг даган мөрдөж, шаардлагатай арга хэмжээг цаг тухайд нь авсан талаар ТУЗ-д эргэн тайлагнан ажиллаж байна.
- Тайлангийн хугацаанд ТУЗ-ийн хараат бус гишүүний хувьд банканд сөргөөр нөлөөлөхүйц буруу зүйл илрүүлээгүй тул ямар нэгэн тодорхой асуудлаар ээлжит бус хурал зарлах шаардлага гаргаагүй.
- ТУЗ нь гаргасан шийдвэр, үндэслэлийн талаар ил тод байж, цаг тухайд нь мэдээлдэг.


- ТУЗ-ийн хуралдаан дээр хараат бус гишүүний хувьд бусад гишүүдтэй зарчмын зөрүүтэй байр суурь 1 удаа илэрхийлсэн бөгөөд хэллэлцэж буй асуудлууд дээр нэмэлт тодруулга авах шаардлагатай бол ТУЗ болон ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, Удирдлагын багаас зохих мэдээллийг авдаг.
- Тайланд заасан хурлуудаар хэлэлцүүлсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийг хуульд заасан байдлаар шийдвэрлэж, саналаа өгч баталгаажуулсан болно.
- Тайлангийн хугацаанд ТУЗ-өөс гаргасан бүх шийдвэрийн санал хураалтад миний зүгээс сайтар судласны үндсэн дээр дэмжсэн болно.
- ТУЗ-ийн гишүүд болон түүний дэргэдэх хороодын зүгээс засаглалын тогтолцоог сайжруулах, хувьцаа эзэмшигчид болон оролцогч талуудын эрх ашгийг хамгаалах, эрх тэгш байдлыг хангах, МУ-д мөрдөгдөж буй хууль, журамд үйл ажиллагаагаа нийцүүлэн ажиллаж байна.

Д.Түвшинтамир миний бие Монгол банкны Ерөнхийлөгчийн 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 5176 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам"-ын 5 дугаар зүйлийн 5.1-т заасны дагуу ажлын тайланг хүргүүлж байна.

Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Банкны дүрэмд заасан хараат бус гишүүний эрх, үүргээ хэрэгжүүлэн бие даасан, хараат бус, мэргэшсэн байх зарчмыг барьж ажиллахыг чармайж ирсэн болно.

Тайлан бичсэн:

Ариг банкны ТУЗ-ийн хараат бус гишүүн, Аудитын хорооны дарга, Эрсдэлийн удирдлага болон Засаглал, нэр дэвшүүлэх хорооны гишүүн .....

  
Д.Түвшинтамир/